



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 8/13

Тавин

Өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Төрийн сангийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Гишүүд: Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Нярав

2. Байгууллагын хөрөнгийг зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн биелэлтийг тооцож тайлагнан ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.УРАНЦЭЦЭГ